



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ХӨА-2022/01/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: [Tegshdelgerb@audit.gov.mn](mailto:Tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## 1. Аудитын гэрчилгээ



### ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.25 № 01/282  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

АЛАГ-ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
З.НЯМ-ОЧИР ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

##### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Алаг-Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 13.5 сая төгрөгийн залруулаагүй алдаатай, төсвийн санхүүжилтийг 5.6 сая төгрөгөөр илүү зарцуулсан, сумын удирдлага, санхүүгийн албаны хянал сулаас 27.0 сая төгрөгөөр оффисын тавилга, автомашин худалдан авсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төрийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ын 1.4 заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна

##### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч төсөв, санхүүгийн хувьд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх, үүрэг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 140 зорилт, 212 арга хэмжээний хэрэгжилт 83.3 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.



Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



### 3. 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

#### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	757,496.2	969,831.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	182,368.9	368,540.0
33	АВЛАГА	178,886.6	216,651.6
35	БАРАА МАТЕРИАЛ	396,240.8	384,639.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,179,452.1	4,131,343.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	141,126.0	85,647.5
37300	Урт хугацаат зээл	141,126.0	85,647.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,038,326.1	4,045,696.0
39200	Биет хөрөнгө	3,846,098.1	3,876,839.3
39300	Биет бус хөрөнгө	192,228.0	168,856.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,936,948.4	5,101,174.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,071.6	16,719.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,071.6	16,719.8
41300	Өглөг	4,071.6	16,719.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,932,876.8	5,084,455.0
51	Засгийн газрын хувь оролцоо	4,932,876.8	5,084,455.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,708,382.5	2,708,382.5
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,500.0	1,500.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,336,069.9	1,491,078.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	886,924.4	883,494.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,936,948.4	5,101,174.8

#### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,681,260.6	3,346,097.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	187,894.6	300,502.8
110	Орлогын албан татвар	74,927.8	58,030.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	74,927.8	58,030.7
113	Хөрөнгийн албан татвар	1,982.2	89,608.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	110,984.6	152,863.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177,021.3	456,979.8
120	Нийтлэг татварын бус орлого	177,021.3	456,979.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,316,344.8	2,588,615.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,571,951.8	3,141,598.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,571,951.8	3,141,598.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,484,602.2	2,997,004.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,620,479.2	1,760,650.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,700.1	224,064.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,289.4	125,898.4
2104	Хангамж, бараа материалын зардал	77,229.6	131,723.5
2105	Нормативт зардал	90,882.0	326,236.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,227.7	33,273.1
2107	Томилолт, зочны зардал	2,873.2	2,808.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,405.2	55,649.5



2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,515.9	336,699.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,349.6	144,593.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	109,308.8	204,499.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,994.5	41,645.3
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	106,314.3	162,854.2

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,773,199.0	4,773,199.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	53,363.5	53,363.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,826,562.5	4,826,562.5
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	106,314.3	106,314.3
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,932,876.8	4,932,876.8
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,932,876.8	4,932,876.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,845.8	-7,845.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,925,031.0	4,925,031.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,430.2	-3,430.2
19	Тайлант үеийн үр дүн	162,854.2	162,854.2
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,084,455.0	5,084,455.0

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,541,514.8	2,931,991.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	187,894.6	300,502.8
110	Орлогын албан татвар	74,927.8	58,030.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	74,927.8	58,030.7
113	Хөрөнгийн албан татвар	1,982.2	89,608.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	110,984.6	152,863.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,109.8	10,178.5
1181	Газрын төлбөр	18,341.5	21,593.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	80,533.2	121,092.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,275.4	122,527.4
120	Нийтлэг татварын бус орлого	37,275.4	122,527.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,316,344.8	2,508,961.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,304,849.2	2,589,692.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,304,849.2	2,589,692.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,215,006.2	2,431,539.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,609,859.7	1,759,464.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217,060.0	225,717.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,915.5	114,840.5
2104	Хангамж, бараа материалын зардал	73,608.8	76,371.8
2105	Нормативт зардал	97,802.3	124,370.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,722.2	40,333.0
2107	Томилолт, зочны зардал	2,873.2	2,808.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,677.0	65,939.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,487.5	21,692.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,843.1	158,152.9



III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	236,665.6	342,298.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	82,411.6	156,127.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	82,411.6	156,127.7
2200	Дотоод эх үүсвэрээр	82,411.6	156,127.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-82,411.6	-156,127.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	154,254.0	186,171.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,115.0	182,368.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	182,368.9	368,540.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,614,901,500.00	2,490,951,991.46	123,949,508.54	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,444,094,900.00	2,394,489,191.46	49,605,708.54	98.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,386,344,600.00	2,337,770,402.46	48,574,197.54	98.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,688,901,200.00	1,684,697,091.35	4,204,108.65	99.8
210101	Үндсэн цалин	1,207,421,300.00	1,191,890,209.37	15,531,090.63	98.7
210102	Нэмэгдэл	346,076,800.00	360,450,464.95	-14,373,664.95	104.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,048,000.00	6,445,584.71	-397,584.71	106.6
210104	Урамшуулал	88,613,900.00	95,762,739.52	-7,148,839.52	108.1
210105	Гэрээт ажлын хөлс	40,741,200.00	30,148,092.80	10,593,107.20	74.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	227,462,600.00	223,068,529.58	4,394,070.42	98.1
210201	Тэтгэврийн даатгал	159,906,500.00	157,032,527.22	2,873,972.78	98.2
210202	Тэтгэмжийн даатгал	16,889,100.00	16,545,776.68	343,323.32	98.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,511,300.00	13,163,381.33	347,918.67	97.4
210204	Ажилгүйдлийн даатгал	3,377,800.00	3,296,745.54	81,054.46	97.6
210205	Эрүүл мэндийн даатгал	33,777,900.00	33,030,098.81	747,801.19	97.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,586,500.00	114,636,806.78	1,949,693.22	98.3
210301	Гэрэл, цахилгаан	21,076,500.00	20,135,906.78	940,593.22	95.5
210302	Түлш, халаалт	92,000,000.00	93,578,000.00	-1,578,000.00	101.7
210303	Цэвэр, бохир ус	3,510,000.00	922,900.00	2,587,100.00	26.3
2104	Хангамж, бараа материалын зардал	70,060,100.00	65,558,611.75	4,501,488.25	93.6
210401	Бичиг хэрэг	7,037,000.00	7,080,500.00	-43,500.00	100.6
210402	Тээвэр, шатахуун	36,100,800.00	35,242,761.75	858,038.25	97.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,637,000.00	7,637,000.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	4,119,100.00	4,085,550.00	33,550.00	99.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,994,700.00	2,341,300.00	3,653,400.00	39.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,171,500.00	9,171,500.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	99,743,500.00	77,457,083.00	22,286,417.00	77.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,805,700.00	26,458,620.00	1,347,080.00	95.2
210502	Хоол, хүнс	67,998,100.00	47,058,763.00	20,939,337.00	69.2



210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,939,700.00	3,939,700.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	89,537,500.00	88,535,400.00	1,002,100.00	98.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	34,750,000.00	34,750,000.00	0.00	100.0
210602	Тавилга	17,900,000.00	17,900,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	35,887,500.00	34,885,400.00	1,002,100.00	97.2
2107	Томилолт, зочны зардал	2,788,900.00	2,736,900.00	52,000.00	98.1
210702	Дотоод албан томилолт	2,788,900.00	2,736,900.00	52,000.00	98.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,465,000.00	62,869,200.00	4,595,800.00	93.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	62,541,200.00	58,700,400.00	3,840,800.00	93.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,505,000.00	1,750,000.00	755,000.00	69.9
210803	Даатгалын үйлчилгээ	108,900.00	108,900.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	177,900.00	177,900.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	655,000.00	655,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	350,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	127,000.00	127,000.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,799,300.00	18,210,780.00	5,588,520.00	76.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,636,500.00	11,047,980.00	5,588,520.00	66.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,162,800.00	7,162,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,750,300.00	56,718,789.00	1,031,511.00	98.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,750,300.00	56,718,789.00	1,031,511.00	98.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,524,000.00	26,702,489.00	821,511.00	97.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,766,300.00	21,766,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,460,000.00	8,250,000.00	210,000.00	97.5
22	Хөрөнгийн зардал	119,556,600.00	96,462,800.00	23,093,800.00	80.7
223001	Бусад хөрөнгө	119,556,600.00	96,462,800.00	23,093,800.00	80.7
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	51,250,000.00	0.00	51,250,000.00	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	51,250,000.00	0.00	51,250,000.00	0.0
III	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,614,901,500.00	2,616,476,888.43	-1,575,388.43	100.1
31	Улсын төсвөөс санхүүжих	1,755,403,200.00	1,722,895,682.98	32,507,517.02	98.1
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,667,125,100.00	1,634,617,582.98	32,507,517.02	98.1



310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	88,278,100.00	88,278,100.00	0.00	100.0
32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	648,768,300.00	750,828,255.45	-102,059,955.45	115.7
320001	Орон нутгийн төсвөөс	648,768,300.00	750,828,255.45	-102,059,955.45	115.7
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	33,485,200.00	32,030,600.00	1,454,600.00	95.7
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,485,200.00	32,030,600.00	1,454,600.00	95.7
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	177,244,800.00	110,722,350.00	66,522,450.00	62.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	99,351,100.00	-49,351,100.00	198.7
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	11,371,250.00	-9,371,250.00	568.6
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	125,244,800.00	0.00	125,244,800.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	36,787,966.00	-36,787,966.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	161,050,916.00	-161,050,916.00	
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	870.00	870.00	0.00	100.0
61	Байгууллагын тоо	6.00	6.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00	0.00	100.0
62	Ажиллагаагаар тоо	148.00	148.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	13.00	13.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	79.00	79.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	52.00	52.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	0.00	100.0
63	Суралцагчдын тоо (жилийн дунджаар)	568.00	568.00	0.00	100.0
630	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	456.00	456.00	0.00	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	456.00	456.00	0.00	100.0
631	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	112.00	112.00	0.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	112.00	112.00	0.00	100.0
65	Орон тооны мэдээлэл	148.00	148.00	0.00	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	0.00	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	51.00	51.00	0.00	100.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00	0.00	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20.00	20.00	0.00	100.0



650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	55.00	55.00	0.00	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	184,383,991.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	184,383,991.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	152,433,991.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,481,051.00
210101	Үндсэн цалин	70,481,051.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,935,449.00
210201	Тэтгэврийн даатгал	4,185,919.00
210202	Тэтгэмжийн даатгал	687,354.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	184,518.00
210204	Ажилгүйдлийн даатгал	502,874.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,374,784.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	203,714.82
210301	Гэрэл, цахилгаан	203,714.82
2104	Хангамж, бараа материалын зардал	11,302,071.00
210401	Бичиг хэрэг	1,200,800.00
210402	Тээвэр, шатахуун	7,281,271.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,780,000.00
2105	Нормативт зардал	46,913,745.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,903,113.00
210502	Хоол, хүнс	9,010,632.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,203,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,756,000.00
210604	Урсгал засвар	2,447,600.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00
210702	Дотоод албан томиллолт	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,840,354.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,840,354.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,482,007.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	677,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,805,007.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,950,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,950,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	184,383,991.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	184,383,991.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	88,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,703,691.82
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,701,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	135,891,100.00

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн



санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч З.Ням-Очир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудын аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд гарсан алдаа, зөрчил, төсвийн төлөвлөлт, санхүүгийн тайлан дахь залруулга, төрийн сангийн хяналт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 14-өөс 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Г.Эрдэнэчимэг гүйцэтгэн, чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хариуцан хэрэгжүүлэв.

Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/121 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Алаг-Эрдэнэ сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч буюу засаг дарга, төрийн захиргааны чиг үүрэг нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын үйл ажиллагаатай холбогдсон хөдөлмөрийн харилцааг хууль эрх зүйн хэмжээнд уялдуулан зохицуулах, Төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, түргэн шуурхай хүргэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах, төрийн албаны чанар хүртээмжийг дээшлүүлэх, шинэ санаа санаачилгыг дэмжих үйл ажиллагаа юм.

Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Иргэдээ сонсъё” гэсэн эрхэм зорилгоо дэвшүүлэн ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсан байна.

2. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн бодлогын талаар авах арга хэмжээний талаар”

Сумын дотоод хяналтын нэгжийн хэрэгжүүлсэн хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын төрийн сангийн дотоод хяналтын нэгжийн 2021 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу Алаг-Эрдэнэ сумын төсөвт байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, баримт нотолгоонд үндэслэн тайлан бичиж, төсөвт байгууллагуудад танилцуулж зөвлөмж өгч ажилласан байна.



Сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах байгууллагын хүрээнд боловсруулагдан АЗД-ын 2019 оны А/243 дугаар захирамжаар батлагдсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь шинэчлэгдсэн, өөрчлөлт орсон зарим, заавар, журамтай нийцүүлж өөрчлөлт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,141.6 сая төгрөгийн 2 хувь буюу 62.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 50.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 182.3 сая, эцсийн үлдэгдэл 368.5 сая төгрөг болж 186.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	0.0	0.0
Банканд байгаа бэлэн мөнгө	182.3	368.5	186.2
<b>Дүн</b>	<b>182.3</b>	<b>368.5</b>	<b>186.2</b>
<b>Үүнээс: Байгууллагаар харуулбал:</b>			
Орон нутгийн ерөнхий орлого	145.5	207.4	61.9
Сум хөгжүүлэх сан	27.9	138.0	110.1
Орон нутгийн хөгжлийн сан	8.8	23.0	14.2
<b>Нийт дүн</b>	<b>182.3</b>	<b>368.5</b>	<b>186.2</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 368.5 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэхэд сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт 110.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн төсвийн орлого 61.9 сая төгрөгөөр нэмэгдэж орсонтой холбоотой байна.

#### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ байхгүй байна.



### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 178.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 216.6 сая төгрөг болж 32.9 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №2 Авлага

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт, бууралт/+, -/
<b>Авлагын төрлөөр</b>	<b>178.7</b>	<b>216.6</b>	<b>32.9</b>
Ажиллагчидтай холбоотой авлага	0.005	0.57	0.56
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	79.8	79.8
Байгууллагаас авах авлага	2.2	10.8	8.6
Зээлийн хүүгийн авлага	24.5	17.3	-7.2
Зээлийн авлага	151.8	107.9	-43.9
<b>Байгууллагын нэрээр</b>	<b>178.7</b>	<b>216.6</b>	<b>32.9</b>
Засаг даргын Тамгын газар	0.0	0.5	0.5
Ерөнхий боловсролын сургууль	1.6	5.6	4.0
Хүүхдийн цэцэрлэг	0.6	0.2	-0.4
Сум хөгжүүлэх сан: <i>Зээлийн авлага</i>	24.5	17.3	-7.2
<i>Зээлийн хүүгийн авлага</i>	151.8	107.9	-43.9
Эрүүл мэндийн төв <i>/Эрүүл мэндийн даатгалын сан/</i>	0.0	79.8	79.8
Орон нутгийн ерөнхий орлого	0.0	5.0	5.0

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Цар тахлын үед үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний ЭМДС-аас авах 79.8 сая төгрөгийн авлага, орон нутгийн ерөнхий орлого дансанд 5.0 сая төгрөгийн санхүүжилтийн авлага тус тус үүссэн байна.

Авлагын эхний үлдэгдлээс сум хөгжүүлэх сангийн авлага 51.1 сая төгрөгөөр барагдсан байна.

### 3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат зээл, хувь хүмүүс олгосон зээл дансны эхний үлдэгдэл 141.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 85.6 сая төгрөг болж өмнөх оноос 55.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 107.9 сая төгрөг байна.

### 3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 396.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 384.6 сая төгрөг болж 11.6 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	75.5	83.9	8.4
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1.2	1.4	0.2
Соёлын төв	7.9	9.4	1.5
Ерөнхий боловсролын сургууль	187.6	162.4	-25.2
Мөнххаан савдаг ОНӨААТҮГ	0.06	0.06	0
Хүүхдийн цэцэрлэг	73.9	41.3	-32.6
Эрүүл мэндийн төв	49.8	86.0	36.2
<b>Нийт дүн</b>	<b>396.2</b>	<b>384.6</b>	<b>-11.6</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны материаллаг өөрчлөлтөд ерөнхий боловсролын Сургуулийн бараа материалын данс 25.2 сая төгрөгөөр буурсан, Хүүхдийн цэцэрлэгийн бараа материалын данс 32.6 сая төгрөгөөр буурсан, Засаг даргын Тамгын газрын бараа материал данс 8.4 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн төвийн бараа материалын данс 36.2 сая төгрөгөөр, Соёлын төвийн бараа материал данс 1.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж нөлөөлсөн байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,038.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,045.6 сая төгрөг болж 7.3 сая төгрөгөөр өссөн байна.



Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Мөнххаан савдаг ОНӨААТҮГ	0.5	0.5	0.0
Засаг даргын Тамгын газар	1,265.0	1,325.0	60.0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.1	6.5	6.4
Соёлын төв	622.4	611.2	(11.2)
Сургууль	754.7	709.7	(45.0)
Хүн эмнэлэг	313.3	332.7	19.4
Цэцэрлэг	1,082.1	1,059.8	37.0
<b>Нийт</b>	<b>4,038.3</b>	<b>4,045.6</b>	<b>7.3</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө олж бэлтгэсэн байдлыг авч үзвэл: Худалдан авсан 79.4 сая төгрөг, хандиваар 2.3 сая төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар 170.1 сая төгрөг, дахин үнэлсэн 99.9 сая төгрөг байна.

Хөрөнгийн зарлага болгосон байдлыг авч үзвэл: Тайлант онд байгуулсан элэгдлийн зардал 308.7 сая төгрөг байна.

АИТХ-ын тогтоолоор нийт 126.7 сая төгрөгийг 0 үлдэгдэлтэй хөрөнгийг данснаас хасаж ашиглах боломжтой хөрөнгийг үнэлэн 41.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэн байна.

**Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийн эхний үлдэгдэл 192.2 сая төгрөг эцсийн үлдэгдэл 168.8 сая төгрөг байна. Тайлант онд ашиглалтгүй байгаа 13.5 сая төгрөгийн программ хангамж данснаас хассан, Соёлын төвийн газрыг илүү бүртгэсэн байсныг 11 сая төгрөгөөр бууруулж 12.7 сая төгрөгөөр бүртгэсэн.

**3.5.8 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 3.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 16.7 сая төгрөг болж 12.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Мөнххаан савдаг ОНӨААТҮГ	2.8	2.8	0.0
Соёлын төв	1.0	0	-1
Ерөнхий боловсролын сургууль	0.06	5.3	5.2
Эрүүл мэндийн төв	0	8.6	8.6
<b>Нийт дүн</b>	<b>3.9</b>	<b>16.7</b>	<b>12.8</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн өр төлбөрийн үлдэгдэл 2.8 сая төгрөг ажилчидтай холбоотой цалингийн өглөг, байгууллагад төлөх НДШ-н өглөг 0.2 сая төгрөг байна. Байгууллагад төлөх 5.04 сая төгрөгийн өглөг санхүүжилтийн өглөг байна. Байгууллагад төлөх 8.6 саяын төгрөгийн өглөг нь Ковид-19 холбоотой үүссэн эм хэрэгсэл, шатахуун, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, цалингийн өглөг байна.

**Засгийн газрын хувь оролцоо данс**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,932.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,084.3 сая төгрөг болж 151.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,709.8	2,709.8	0.0



Хуримтлагдсан үр дүн	1,336.1	1,491.1	155.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	886.9	883.4	-3.5
<b>Нийт дүн</b>	<b>4,932.8</b>	<b>5,084.3</b>	<b>151.5</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 56.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгө данснаас хассаны зөрүү 3.5 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлогыг 3,346.1 сая төгрөгөөр тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 664.8 сая төгрөг буюу 4.0 хувиар өссөн байна.

Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
Татварын орлого	187.8	300.5	112.7	160.0
Татварын бус орлого	177.0	457.0	280.0	258.2
Тусламж санхүүжилтийн орлого	2,316.3	2,588.6	272.3	111.8
<b>Нийт дүн</b>	<b>2,681.3</b>	<b>3,346.1</b>	<b>664.8</b>	<b>124.8</b>

Эрүүл мэндийн төвд корона вирус цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, санхүүжилтийн орлого 495.5 сая төгрөг болсон нь материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.

### 3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 3,911.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	2,571.9	3,141.5	569.6	122.1
Үйл ажиллагааны бус зардал	2.9	41.6	38.7	1,434.5
<b>Нийт дүн</b>	<b>2,574.8</b>	<b>3,183.1</b>	<b>608.3</b>	<b>123.6</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант 2021 онд өмнөх оноос 608.3 сая төгрөгөөр зардал өссөн байна. Зардал өмнөх оноос өссөн нь Эрүүл мэндийн төвийн зардал өссөн нь материаллаг хэмжээгээр нөлөөлсөн байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” –ын хэрэгжилтийг хэрэгжилтийг хянан үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- Сумын ЗДТГ - Оффисын тавилга худалдан авахад 5.5 сая төгрөг зарцуулсан
- Сумын ЗДТГ – Тээврийн хэрэгсэл худалдан авахад 9.8 сая төгрөг зарцуулсан
- Сумын ИТХ -Тайлант хугацаанд тавилга худалдан авахад 1.7 сая төгрөг зарцуулсан

## 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар ТЕЗ-ийн өргөн мэдүүлсэн 2021 оны төсвийн төслийг хэлэлцэн 11 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2,446.2 сая төгрөгийн төсөв баталсан байна.



Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 42 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийж 123.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,596.9 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт 2,614.9 сая төгрөгийн зардлын 1,667.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 88.2 сая төгрөгийг ОНХНС-аас, 648.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 33.4 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 52.0 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс, урьд оны үлдэгдлээс 125.5 сая төгрөгөөр төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар сумын байгууллагуудын төсөвт дараах зохицуулалтыг хийсэн байна. Үүнд: Соёлын төвд 1.7 сая төгрөг нэмэх, цэцэрлэгээс 33.7 сая төгрөгийн хасах, Сургуульд 50.0 сая төгрөгийн нэмэх зохицуулалтыг тус тус хийсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

#### Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 12 дугаар сарын 18-ий өдрийн 11 дугаар тогтоолд зааснаар Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 111.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 312.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 279 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Үйл ажиллагааны орлого	16.2	17.2	106.4	1.0
Хөрөнгийн орлого	15.5	19.7	127.1	4.2
Шууд бус орлого	10.0	10.0	0	-10.0
Хөрөнгө борлуулсны орлого		21.1	0	21.1
Бууны албан татвар	2.2	1.7	80.8	-0.42
Малд ногдуулах албан татвар		87.8	0	87.8
Улсын тэмдэгтийн хураамж	8.3	8.7	105.4	0.44
Түгээмэл тархцатай АМАТ	0.14	0.15	110.8	0.015
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	3.6	1.2	34.9	-2.3
Газрын төлбөр	2.8	13.8	495.9	11.1
Дуудлага худалдаа		7.7	0	7.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.16	0.16	100	0
Ойн нөөц ашигласны төлбөр	45.28	118.6	262.1	73.4
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	0.9	0.9	100.4	0.004
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.5	1.3	90.9	-0.1
<b>Татварын орлогын дүн</b>	<b>106.6</b>	<b>300.5</b>	<b>281.8</b>	<b>193.8</b>
Торгуулийн орлого	5.0	11.8	0.2	6.8
Түрээсийн орлого	0.0	0.0	0.0	0.0
<b>Татварын бус орлогын дүн</b>	<b>5.0</b>	<b>11.8</b>	<b>0.2</b>	<b>6.8</b>
<b>Нийт орлогын дүн</b>	<b>111.6</b>	<b>312.3</b>	<b>279</b>	<b>200.6</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Сумын орон нутгийн орлого 200.6 сая төгрөгөөр давсан нь ойн нөөцийн төлбөр, газрын төлбөр, малд ногдуулах албан татварын орлогын төлөвлөгөө давж биелснээс шалтгаалсан байна.

Шууд бус орлого 10 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 2.3 сая төгрөгөөр, бууны албан татварын орлогын төлөвлөгөө 0.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Хөрөнгө борлуулсны орлого, Малд ногдуулах албан татвар, дуудлага худалдааны орлогыг төлөвлөөгүй нь төсвийг бодитой, судалгаа тооцоотой хийж төлөвлөөгүйтэй холбоотой байна.



**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 125.1 сая төгрөгөөр төлөвлөж 155.76 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 30.66 сая төгрөг буюу 24.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

/Сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	105	125	20
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2.5	2	-0.5
3	Газрын төлбөр	4.2	10.7	6.5
4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11	14.7	3.7
5	Зам ашигласны төлбөр	2.4	3.4	1
6	Үйлдвэрлэлийн зориулалттай ус ашигласны төлбөр	6.7	0.0	-6.7
7	<b>Нийт дүн</b>	<b>131.8</b>	<b>155.8</b>	<b>24.0</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.11 сая төгрөгөөр төлөвлөж 4.62 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 0.49 сая төгрөг буюу 9.5 хувиар дутуу биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.5	0.7	-0.9
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	2.0	1.4	-0.6
3	Агаарын бохирдлын төлбөр	1.6	2.6	1.0
4	<b>Нийт дүн</b>	<b>5.1</b>	<b>4.6</b>	<b>-0.5</b>

Эх сурвалж: Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

### Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 2,614.9 сая төгрөгөөр төлөвлөж, 2,616.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 100.1 хувийн гүйцэтгэлтэй байна. тусламж санхүүжилтийн орлогын төлөвлөгөө биелэхэд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө давж 102.0 сая төгрөгөөр биелсэнтэй холбоотой байна

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 2,614.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,444.1 сая төгрөгийг урсгал зардалд, 119.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 51.2 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн хуваарийн дагуу аймгаас авах санхүүгийн дэмжлэг 537.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг бүрэн санхүүжиж, тусгай зориулалтын шилжүүлэг 1,634.6 сая төгрөгийн санхүүжилт авч 98.0 хувийн гүйцэтгэлтэй, ОНХС-ын шилжүүлгээр 88.2 сая төгрөг авахаас бүрэн санхүүжиж харьяа байгууллага, тусгай сангуудад санхүүжилтийг бүрэн олгож ажилласан байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 52.0 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 110.7 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна.

### Төсвийн зарлагын талаар:



Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,490.9 сая төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” хэрэгжсэнтэй холбоотой зарим зардлыг хэмнэн ажилласантай холбоотой байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 4.2 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 1.9 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 4.5 сая төгрөг
- Нормативт зардал 22.2 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 4.6 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5.6 сая төгрөг
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 0.8 сая төгрөг
- Хөрөнгийн зардал 23.0 сая төгрөг

Сум хөгжүүлэх сангаас 51.2 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч зээлийн олголт хийгээгүй байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 9.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 32.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээнд 104.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 76.6 сая төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 23.0 сая төгрөг байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлэг, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн дүн болох нийт 824.3 сая төгрөгийн гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд харьяа байгууллагуудын урсгал үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийн дүн болох нийт 769.9 сая төгрөгийн гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр нь дээд шатны төсөв захирагчаас 45.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 2.7 сая төгрөг, ЭМЯ, ЭМГ-аас Ковид 19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагааны дэмжлэгт 135.8 сая төгрөг нийт 184.3 сая төгрөгийг орлогоос бүрджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Алаг-Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 292.9 сая төгрөгийн алдаа, 40.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.



Төрийн сангийн санхүүгийн алба ерөнхий боловсролын сургуульд 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг илүү олгож төсвийн санхүүжилт хэтрүүлэн зарцуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд илэрсэн 4.7 сая төгрөгийн залруулаагүй алдаа нэгтгэгдсэн.

Сум хөгжүүлэх сангаас 51.2 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч зээлийн олголт хийгээгүй байна.

Тайлант хугацааны эцэст 108.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, 85.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн авлагатай байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.2.2. “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” заалттай нийцэхгүй байна.

Нягтлан бодогч М.Нямгэрэлийг сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогчийн албан тушаалд түр томилсон /түр томилогдоод 7 сар ажиллаж байгаа/ нь Сангийн сайдын 2012 оны 294 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын зарим заалттай нийцэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянан үзэхэд:

1. Сумын Засаг даргын Тамгын газар - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 95.0 сая төгрөгийн 8 мэдээлэл байршуулаагүй, 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.
2. Ерөнхий боловсролын сургууль - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8, 6.8.1-д заасан 40.8 сая төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна. Өмнөх аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хэрэгжүүлээгүй тул зөрчил давтан гаргахгүй байх, таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн байна.
3. Хүүхдийн цэцэрлэг - Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.8, 6.8.1-д заасан 40.8 сая төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Сангийн яамны төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэх системд байгууллагын нэрийг үнэн зөв мэдээлээгүй, байгууллагын гэрчилгээний нэр, улсын бүртгэл дэх нэр, дүрмийн сангийн дүн зөрүүтэй байна. Тухайлбал: Хүн эмнэлэг, сургууль, цэцэрлэг гэж бүртгэсэн байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.7. Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй



байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана” заалтын дагуу хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд алданги тооцоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмж биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2022 оны төсвийн талаар баримтлах бодлогын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн орлогыг батлагдсан нэр төрлөөр биелүүлсэн эсэх, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын хэрэгжилтийг хянан үзэх нь зүйтэй.

## 2. 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ОНӨААТҮГ, нийт 10 санхүүгийн тайлан, 10 төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Зөрчилгүй дүгнэлт
2	Ерөнхий боловсролын сургууль	Зөрчилгүй дүгнэлт
3	Хүүхдийн цэцэрлэг	Сөрөг дүгнэлт
4	Эрүүл мэндийн төв	Зөрчилгүй дүгнэлт
5	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Түүвэрт хамрагдсан
7	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан
8	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
9	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан
10	Мөнх хаан савдаг ОНӨХХК	Түүвэрт хамрагдсан

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 230.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10.1 сая төгрөгийн алдааг залруулж, 220.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, сөрөг санал дүгнэлт авсан хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчид хариуцлага тооцох санал хүргүүлээ.

Төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 319.3 сая төгрөгийн 7 алдаа, 31.9 сая төгрөгийн зөрчил илэрч 41.8 сая төгрөгийн алдаа залруулж, 4.9 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 203.0 сая төгрөгийн 3 зөрчилд 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Тусламж санхүүжилтийн зарлагын 5.0 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 5.0 сая төгрөгийн залруулах бичилт хийсэн.

Алаг-Эрдэнэ сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 329.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлагналтай холбоотой 264.0 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

#### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 4.3 Албан шаардлага

Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан тул Төрийн аудитын тухай хуулийн 42.1.”Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг



хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” заалтын дагуу цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн болно.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Сум хөгжүүлэх сантай холбоотой асуудал**

**1.1** Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас 51.2 сая төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч зээлийн олгоогүй, тайлант хугацааны эцэст 108.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, 85.6 сая төгрөгийн урт хугацаат зээлийн авлагатай байгаа нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.2.2. “Сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг байна.

**1.2** Өгсөн зөвлөмж: Тайланд батлагдсан хэмжээгээр зээлийн олголт хийж төсвийн гүйцэтгэл ханган ажиллах, хугацаа хэтэрсэн 193.6 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн авлагагүй байх.

##### **2. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал:**

**2.1** Илрүүлэлт: Төрийн сангийн санхүүгийн алба ерөнхий боловсролын сургуульд 5.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг илүү олгож төсвийн санхүүжилт хэтрүүлэн зарцуулснаас татаас санхүүжилтийн авлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.13.3. “Төрийн сан энэхүү журмын 7.11, 7.12-т зааснаас бусад тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийх”-ийг хориглоно заалтыг зөрчсөн байна.

**2.2** Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийг баримтлан ажиллаж төрийн сангийн хяналт сайжруулж ажиллах.

##### **3. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө давж биелсэн боловч шууд бус орлого 10.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний төлбөр 2.3 сая төгрөгөөр, бууны албан татварын орлогын төлөвлөгөө 0.4 сая төгрөгөөр тус тус тасарсан, хөрөнгө борлуулсны орлого, малд ногдуулах албан татвар, дуудлага худалдааны орлогыг төлөвлөөгүй нь төсвийг бодитой, судалгаа тооцоотой хийж төлөвлөөгүйтэй холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, нэр төрлөөр бүрэн биелүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байх.

##### **4. Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээтэй холбоотой асуудал**

**4.1** Илрүүлэлт: Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4, 1.6 дахь заалтыг хэрэгжүүлэхэд сумын удирдлага, санхүүгийн албаны хяналт сулаас 27.0 сая төгрөгийн зөрчил гарсан байна.

**4.2** Өгсөн зөвлөмж: Засгийн газар болон бусад эрх бүрий байгууллагаас тухайн жилийн төсөвтэй холбоотой гаргасан тогтоол, тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж дахин зөрчил гаргахгүй байх.



**5. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГАРСАН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

5.1 Илрүүлэлт: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 525.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлд 13.5 сая төгрөгийн залруулаагүй алдаа нэгтгэгдсэн байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн тул хэрэгжилтэд анхаарч ажиллан, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн ирүүлэх. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл дэх 13.5 сая төгрөгийн залруулаагүй алдааг залруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>										
Алаг-Эрдэнэ сумын ТТЗ	6	230.7	2	10.1			1		3	220.6
Харьяа байгууллагуудын зөрчил										
Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	2	28.4					1	27.0	1	1.4
Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль	1	26.4	1	26.4						
Алаг-Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төв	1	3.5							1	3.5
Алаг-Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг	6	292.9	2	279.4					1	13.5
<b>Дүн</b>	<b>16</b>	<b>581.9</b>	<b>5</b>	<b>315.9</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>27.0</b>	<b>5</b>	<b>225.5</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
Харьяа байгууллагуудын зөрчил										
Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	1	95.0							1	95.0
Алаг-Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль	1	67.2							1	67.2
Алаг-Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг	1	40.8							1	40.8
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>203.0</b>							<b>3</b>	<b>203.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>19</b>	<b>784.9</b>	<b>5</b>	<b>315.9</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>27.0</b>	<b>8</b>	<b>428.5</b>